

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/35.

Арвайхээр сум

Судалгааны ажил зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11 дэхь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаар хүн амын дундах хандлага, дадал”-ыг судлах судалгааны багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Судалгааны арга, аргачлал”-ыг хоёрдугаар, судалгааны асуумжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Судалгааг 2022 оны 11 дүгээр сард багтаан хийж, үр дүнг тайлагнахыг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-т даалгасугай.

3. Судалгааны ажилд шаардагдах зардлыг Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын “Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн харилцаа холбоог сайжруулах, иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх” төслийн санхүүжилтээс зарцуулахыг ерөнхий санхүүч (Б.Валя)-д зөвшөөрсүгэй.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2022
оны 11 дугаар сарын 10-ны өдрийн
4/35 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




“КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ТАЛААРХ
ХҮН АМЫН ДУНДАХ ХАНДЛАГА, ДАДАЛ”-ЫН
СУДАЛГААГ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Овог	Нэр	Байгууллага	Албан тушаал
1.	Мангалжав	Золзаяа	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Судалгааны багийн ахлагч
2.	Цогбадрах	Эрхномуун	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
3.	Батжаргал	Оюунчимэг	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
4.	Мөнхбат	Ганцэцэг	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
5.	Энхбаатар	Лхагвадулам	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
6.	Дэмбэрэлданзан	Нацагням	Эрүүл мэндийн газар	Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
7.	Цэдэнсодном	Рэгзэдмаа	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
8.	Цэрэндорж	Сонинбаяр	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн
9.	Цэдэнсодном	Сугарсүрэн	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн,

				судалгааны гишүүн	багийн
10.	Болоо	Долзодмаа	Эрүүл мэндийн газар	Нийгмийн мэндийн мэргэжилтэн, судалгааны гишүүн	эрүүл хэлтсийн багийн

Эрүүл мэндийн газрын даргын 2022
оны 11 дугаар сарын 10-ны өдрийн
4/35 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ТАЛААРХ
ХҮН АМЫН ДУНДАХ ХАНДЛАГА, ДАДАЛ”-ЫГ СУДЛАХ
СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ**

УДИРТГАЛ.

1. Судалгааны ажлын үндэслэл:

БНХАУ нь 2019 оны сүүлээр эндэгдэл өндөртэй, уушгины үрэвсэл тархаж эхэлсэн тухай ДЭМБ-д мэдээлсэн. Энэ нь 21-р зуун гарсаар коронавирус хүн төрөлхтөнд цар тахлын аюул заналыг гурав дахь удаагаа үзүүлсэн тохиолдол болсон. Шинэ коронавирусээр сэдээгдсэн өвчнийг ДЭМБ-аас (КОВИД)-19 хэмээн нэрлэж, 2020 оны 3 дугаар сарын 11-нд цар тахал гэж зарласан бөгөөд 2022 оны 10-р сарын 11-ний өдрийн байдлаар Дэлхийн 216 улс орон, дэвсгэр нутагт тархан 627 сая гаруй хүнийг өвчлүүлж, 6.562.012 хүн нас барсан, Монгол улсад 983.610 хүн өвчилж, 2179 хүн нас бараад байгаа бол Өвөрхангай аймгийн хэмжээнд 23310 хүн өвчилж 37 иргэн нас барсан байна. (ДЭМБ 2022 оны 10-р сар)

Олон улсын эрдэмтдийн судалгаагаар (Ковид-19) халдварын үед тархалтыг зогсооход дан ганц дархлаажуулалт бус бусад нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахгүй бол халдвар тархах эрсдэл өндөр гэж тогтоосон байна.

(КОВИД-19)-ын цар тахал нийтийн дунд тархахад хүн амын зан үйлээс ихээхэн хамаарах бөгөөд өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нэн тэргүүний ажил болно. Хүн амын коронавируст халдварын талаарх хандлага, дадал, ойлголтыг тогтоох нь урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг эрчимжүүлэхэд ихээхэн тус болно.

Иймээс коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хүн амын ойлголт, мэдээллийг үнэлэх урьдчилан сэргийлэх зан үйл болох хандлага, дадлыг тодорхойлж, хүн амыг хэрэгцээт мэдээллээр хангах, хандлага, дадлыг төлөвшүүлэх арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх нь нэн тэргүүний асуудал болж байна.

2. Судалгааны ажлын зорилго:

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын хүн амын коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх талаарх хандлага, дадлыг үнэлж нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулан, хэрэгжүүлэх.

3. Судалгааны ажлын зорилт:

- Судалгаанд хамрагдсан хүн амын цар тахлын үеийн урьдчилан сэргийлэх хандлага, дадлыг судлан тогтоох
- Судалгааны үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх

4. Судалгааны ажлын таамаглал

Хүн амын дундах коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хандлага, дадал нь хүн амын насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, байршлаас хамааран ялгаатай байна.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА АРГА ЗҮЙ

1. Судалгааны ажлын арга ба загвар:

Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх хандлага, дадлын судалгаанд нэг агшингийн судалгааны загвар, чанарын аргыг хэрэглэнэ. Мөн судалгаанд “Коронавируст халдварын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал, ойлголтыг тогтоох үндэсний судалгаа”-ны асуумжийг өөрийн орон нутгийн нөхцөлд нийцүүлэн боловсруулж ашиглана.

2. Судалгааны ажлын хамрах хүрээ, түүвэр:

2022 оны Арвайхээр сумын нийт амын статистик мэдээллээс зорилтот бүлэг /өсвөр үеийнхэн, ахмад настан, иргэд/ тус бүрээс 100 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар төлөөллийг сонгон авч 10 хүний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлагыг хийнэ.

3. Судалгаанд хамруулах хүрээ:

Чанарын судалгаа: Бүлгийн ярилцлагын аргыг ашиглана. Үүнд:

- Зорилтот бүлэг тус бүрийн төлөөлөлтэй бүлгийн ярилцлага хийж, тухайн бүлгийн хүмүүсийн хандлага, дадлыг судалж, урьдчилан сэргийлэхэд тулгамдаж буй бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлно.

4. Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн

Чанарын судалгаанд хэрэглэх ярилцлагын удирдамж нь дараах үндсэн асуудлуудыг багтаасан байна.

- (КОВИД-19)-ын халдварын эрсдэлийн талаарх ойлголт, өвчлөх эсэх, өртөх магадлал, өвдлөө гэхэд хүндрэх эрсдэлийн талаарх ойлголт, хандлага
- (КОВИД-19)-тэй холбоотой хувь хүн, айл өрх, нийгэмд гарч буй эерэг, сөрөг нөлөөллүүд, түүнд өртсөн эсэх
- Ярилцлагын явцад дадлыг ажиглалтын хуудсаар үнэлнэ.

5. Мэдээлэл цуглуулалт:

Зорилтот эх олонлогоос түүвэрлэгдсэн иргэдийг хамруулан урьдчилан боловсруулсан асуумжийг ашиглан мэдээллийг цуглуулна. Мэдээлэл цуглуулалтад эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн 10 мэргэжилтэн ажиллах ба судалгааг 2022 оны 11-р сарын 30-ны дотор хийж гүйцэтгэнэ.

6. Мэдээллийн чанар:

- Түүврийн нэгжийн жагсаалтыг бүрэн бэлтгэх, сонгогдсон нэгжийг судалгаанд заавал хамруулах
- Асуулгын хуудас болон зааварт заасан чиглэлийн дагуу мэдээллийг цуглуулна. Мэдээлэл цуглуулах явцад ойлгомжгүй зүйл, бэрхшээл тулгарсан үед зөвхөн судалгааны багийн ахлагчтай зөвлөлдөж, асуудлыг шийдэх байдлаар ажиллана.

7. Мэдээлэл боловсруулалт:


Чанарын судалгааны аргыг ашиглан олж авсан мэдээллүүдийг ангилан, судалгааны арга зүйг баримтлан боловсруулалт хийнэ. Үүний дараа үнэлгээний удирдамжийн дагуу багц кодыг боловсруулж, бүх ярилцлагуудыг кодлоно. Кодлолтоор нийтлэг болон ялгаатай хүчин зүйлд үндэслэн spss 23 программ дээр дүн шинжилгээ хийнэ.

Хувь хүний мэдээллийг зөвхөн судалгааны ажилд ашиглах бөгөөд судалгааны үр дүнг мэдээлэхдээ хувь хүний нууцыг хадгална.

8. Хүлээгдэж буй үр дүн:

- Судалгаанд хамрагдсан иргэдийн коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх хандлага, дадлыг тогтоосон байна.
- Хүн амын дундах коронавируст халдвар /КОВИД-19/-ын талаарх хэрэгцээт мэдээлэл, цаашид ямар мэдээллийн эх сурвалжийг ашиглан, иргэдэд хүргэх мэдээллийн чиглэл тодорхой болсон байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2022
оны 11 дугаар сарын 10-ны өдрийн
А/35 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАЛААРХ
ХҮН АМЫН ХАНДЛАГА, ДАДАЛ ТОГТООХ ЧАНАРЫН
СУДАЛГААНЫ УДИРДАМЖ (ХҮН АМД ЗОРИУЛСАН)

Байршил.....

Зорилтот бүлэг.....

1. Коронавируст халдварын талаар ярилцая. Та надад коронавируст халдварын дамжих зам, ямар шинж тэмдэг илрэх, хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх өөрийн мэдэж байгаа зүйлийг ярьж өгөөч? (Ярилцагч тодруулж асууж болно)
2. Анх Коронавируст халдвар гарахад хэрхэн хүлээж авсан бэ? Одоо та яаж хүлээж авч байна вэ? Хэрвээ өөрчлөгдсөн бол юу нөлөөлсөн гэж бодож байна вэ?
3. Коронавируст халдварын талаар өдөр тутамдаа мэдээлэл авдаг уу? Ихэвчлэн хаанаас мэдээлэл авдаг вэ? Яагаад?
4. Та 2019 оны 12 дугаар сараас хойш Засгийн газраас болон аймаг орон нутгаас коронавируст халдварын эсрэг авч хэрэгжүүлсэн ямар үйл ажиллагааг дэмжиж, ямар үйл ажиллагааг нь буруушааж байна вэ? Яагаад?
5. Таны бодлоор цаашид хүн ам Коронавируст халдвараас сэргийлэх талаар ямар арга хэмжээг аваасай гэж хүсч байна? Хэрхэн, яаж хэрэгжүүлэх вэ?
6. Танай орон нутагт халдвар дахин тархлаа гэхэд та бүхэн бэлэн байна уу? Яагаад?
7. Та Коронавируст халдвараар өвчилсөн үү? Хэдэн удаа өвдсөн бэ? Цаашид өөрийгөө халдвар авах эрсдэлтэй гэж бодож байна уу? Яагаад?
8. Та Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан уу? Хэдэн тун вакцин хийлгэсэн бэ? Та сэргээх тунд хамрагдах уу, шаардлагатай гэж үзэж байна уу?
9. Таны бодлоор Коронавируст халдварын эсрэг вакцин үр дүнтэй юу? Яагаад?
10. Миний асуугаагүй Коронавируст халдвартай холбоотой өөр санал танд байна уу?

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАЛААРХ ХҮН
АМЫН ХАНДЛАГА, ДАДАЛ ТОГТООХ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ
УДИРДАМЖ (ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН)

Байршил.....

Зорилтот бүлэг.....

1. Коронавируст халдварын талаар ярилцая. Та надад коронавируст халдварын дамжих зам, ямар шинж тэмдэг илрэх, хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх өөрийн мэдэж байгаа зүйлийг ярьж өгөөч? (Ярилцагч тодруулж асууж болно)
2. Анх Коронавируст халдвар гарч сургууль хаахад хэрхэн хүлээж авсан бэ? Тэгвэл одоогийн байдал ямар байна вэ? Яагаад?
3. Чи болон танай үеийнхэн хөл хорионы үед юу хийсэн бэ? Дэлгэрүүлж яриулна
4. Коронавируст халдварын талаар өдөр тутамдаа мэдээлэл авдаг уу? Ихэвчлэн хаанаас мэдээлэл авдаг вэ? Яагаад?
5. Та 2019 оны 12 дугаар сараас хойш Засгийн газраас болон аймаг орон нутгаас коронавируст халдварын эсрэг авч хэрэгжүүлсэн ямар үйл ажиллагааг дэмжиж, ямар үйл ажиллагааг нь буруушааж байна вэ? Яагаад?
6. Таны бодлоор цаашид хүн ам Коронавируст халдвараас сэргийлэх талаар ямар арга хэмжээг аваасай гэж хүсч байна? Хэрхэн, яаж хэрэгжүүлэх вэ?
7. Та Коронавируст халдвараар өвчилсөн үү? Хэдэн удаа өвдсөн бэ? Цаашид өөрийгөө халдвар авах эрсдэлтэй гэж бодож байна уу? Яагаад?
8. Та Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан уу? Хэдэн тун вакцин хийлгэсэн бэ? Та сэргээх тунд хамрагдах уу, шаардлагатай гэж үзэж байна уу?
9. Таны бодлоор Коронавируст халдварын эсрэг вакцин үр дүнтэй юу? Яагаад?
10. Миний асуугаагүй Коронавируст халдвартай холбоотой өөр санал танд байна уу?